МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 04 өдөр Дугаар А/628 Мөрөн сум

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн "Хоймор нутгийн ирээдүйн хүчтэн" төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд "Хоймор нутгийн ирээдүйн хүчтэн өсвөр үе, залуучуудын цомын аварга шалгаруулах үндэсний бөхийн тэмцээн"-ийг 2023 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Дээрх тэмцээний зохион байгуулалтад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга (Б.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6712011455